

БАТЛАВ. ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Б.ГАНЗОРИГ

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН “ТОХИЖИЛТ- САЙНШАНД” ХОТ ТОХИЖИЛТЫН
ГАЗРЫН АЛБАН КОНТОРЫН ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: “Тохижилт- Сайншанд” хот тохижилтын газрын албан
конторын засварын ажил
Төслийн дугаар: ОНТХО/ХА-32/2020

Сайншанд хот
2020 он

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020.02.14

Дорноговь аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Тохижилт- Сайншанд” хот тохижилтын газрын албан конторын засварын ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2020 оны 02-р сарын 28-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө хаягаар tender.gov.mn цахим хуудсаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 02-р сарын 28-ны 10 цаг 30 минутад нээнэ.

**Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй.
Дотоодын давуу эрхийн зөрүү тооцно.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Дорноговь аймаг Сайншанд хот 3-р баг нутгийн удирдлагын ордон
1 давхар 106 тоот Утас:7052-2224**

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх-/д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендериийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендериийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендериийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендериийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендериийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендериийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендериийн арифметик алдааг

залруулах

шалгаж дараах байдлаар залруулна:

- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэндэйг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. **Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ГУРАВ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Сүүлийн [1] жилийн /2019 он/ санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт ирүүлэх шаардлагатай. Санхүүгийн тайлан ирүүлэх шаардлагагүй</p> <p>Сүүлийн [1] жилийн /2019 он/ хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын туршлагын мэдээлэл /эрээээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлцэн актын хуулбар/ ирүүлэх</p> <p>Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 1 жилийн орлого төсөвт өртгийн 80 хувиас багагүй байх /2019 оны борлуулалтын орлогыг цахим системээс дуудаж үзнэ/</p> <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Төсөвт өртгийн 80 хувиас багагүй байх.</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай.</p> <p>Үүнд: БХБСайдын -2.1.1 Барилгын засвар, засал чимэглэл, орчны тохиожилт /БА-8.1/, ажилбарын заалт бүхий хүчинтэй хугацаа дуусаагүй барилгын тусгай зөвшөөрөлтэй байна.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Сайншанд сум, 3 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 1 давхар 106 тоот</p> <p>Огноо: 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 00 минутаас өмнө</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Сайншанд сум, 3 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 1 давхар 103 тоот</p> <p>Огноо: 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ТОӨЗ 2.3	<p>Долдугаар бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар 2. Оролцогч компанийн танилцуулга 3. Ажлын зураг, тоо хэмжээний дагуу тооцсон төсөвтэй, эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулсан байна. /Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй төсвийн норм үнэлгээгээр тооцно/ 4. Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны график гарган баталгаажуулж ирүүлнэ. 5. Тусгай зөвшөөрлийн баталгаажсан хуулбар /гэрээ болон хавсралтын хамт хүчинтэй/ 6. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл, иргэний үнэмлэхийн баталгаажсан хуулбар 7. Харилцагч бүх банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх 8. Татварын газрын тодорхойлолтыг цахим системээс дуудаж

	<p>үзнэ тендер нээхэд өргүй байх шаардлагатай</p> <p>9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</p> <p>10. Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулах</p> <p>11. Гэрээг гүйцэтгэх удирдах болон техникийн голлох боловсон хучний чадвар, туршлагын талаарх мэдээлэл</p> <p>12. Дээрх шаардлагатай тодорхойлолтуудыг тендер зарласан өдрөөс хойш авсан байх</p> <p>13. Машин механизм тоног төхөөрөмжийн судалгааны жагсаалтыг бодит байдлын фото зураг, холбогдох баримт бичгийн хамт ирүүлэх</p> <p>14. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгавар, техникийн нөхцлийн дагуу чанарын өндөр түвшинд тухайн ажлыг гүйцэтгэн дуусгаж ашиглалтад хүлээлгэн өгөх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ.</p> <p>15. Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт /Adobe PDF/ шилжүүлж, цахим хэлбэрээр ирүүлэх ба ирүүлсэн бүх материал тод, гаргастай байх шаардлагатай.</p> <p>16. ТШХ-д шаардсан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно</p>
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: “Тохижилт- Сайншанд” хот тохижилтyn газрын албан kontорын засварын ажил ОНТХО/ХА-24/2020 дугаар бүхий нэг багц ажил

"Тохижилт Сайншанд" хот тохижилтын газрын конторын барилгын засварын ажил

А Ж Л Ы Н Т О О Х Э М Ж Э Э

2020/02/03

Дл	А ж и л б а р ы н и э р	Хэмжих иэгж	Тоо
01. Буулгах ажил			
1	Дотор хана таазны суларч хөндийрсөн шаврыг хөвхөлж унагах	м2	206.44
2	Хуучин будагтай ханын гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	820.82
3	Хуучин будагтай таазны гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м2	320.80
4	Паркетийн шал задалж буулгах	м2	92.90
5	Ариун цэвэр, душны өрөөний шалны хавтанцрыг задалж буулгах	м2	37.04
6	Ариун цэврийн өрөөний, ханын хавтанцар задалж буулгах	м2	162.83
7	Хүйтмал материалан дээрэвр буулгах	м2	584.22
8	Хүчинтэй дээрх хуучин бетоны муудсан хэстийг задалж буулгах	м3	4.40
9	Хамар ханын тоосон ерөг, хаалга гаргах хана буулгах	м3	6.45
10	Барилгын дээрээр дээрх шавар буулгаж автомашинд ачиж, зайлцуулах	м3	17.53
02. Дотор заслалын ажил			
11	Дотор хананд т цементэн зуурмагаар шаврын засвархийх	м2	138.30
12	Таазны 10м2 талбайтай бетоной гадаргууд шаврын засварыг цементэн зуурмагаар 20мм зузаантай хийх	м2	53.70
13	Хананд тэгшилгээ хийж сайн чанарын эмульсийн будгаар будах	м2	778.78
14	Гал тогооны хананд тэгшилгээ хийж онцгийн тосон будгаар гар аргаар сайн чанартай будах	м2	42.04
15	Үгсармал хавтгаалжин таазанд заслал хийх	м2	320.80
16	Таазанд тэгшилгээ сайн чанарын эмульсийн будгаар будах	м2	320.80
17	Дотор амалгаанд тэгшилгээ хийж сайн чанарын эмульсийн будгаар будах	м2	50.20
18	Плита наах хананд шавардлагтаа хийх	м2	32.30
19	Душны өрөөний ханын 1.6 метрийн түвшинд плита наах	м2	32.30
20	Ариун цэвэр, душны хувцасны өрөөний ханыг 3D хавтангийн бүрэх $h=1.6$ метр/	м2	67.44
21	Коридоорт хувцасар рамтай давхар ширинийн багцтай халгатай ширин хана уграх 2.87x1.68м	блок	1.00
22	Ариун цэвэр, душны өрөөний таазанд лампирэн хавтан өнгөлгөө хийх	м2	37.04
23	Ариун цэврийн өрөөнд зориулалтын онгот хавтангийн тусгаарлах хана хийх	м2	9.84
24	1/2-ын тоосгоор хамар хана ерөх	м2	22.11
25	Хаалга битгүүдэж ерөх	м3	1.24
26	Шинээр ерсэн болон битгүүлсэн хана цемент шохойн зуурмагаар гарцаар сайн чанартай шавардах	м2	49.30
27	Гадна дотор тоосон хананд 3 м2 хүргэл талбайтай хаалга уграх/1.68x5ш, 1.89x5ш/	м2	17.85

"Тохижилт Сайншанд" хот тохижилтын газрын конторын барилгын засварын ажил

Барилгын тоосоо - 1,0

1

Report Chaka_2006

Д/з	А жи л б а ры н и э р	Хэмжих иэж	Тоо
03. Шалины ажил			
28	20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м ²	92.90
29	OSB хавтангаар өрөө тасалгааны муудсан шаланд тэгшилгээ хийх	м ²	27.90
30	Зөвлөвчтэй паркетан шал угсрал	м ²	92.90
31	Хүйтэн түрхлэг дээр хулдаас нааж шал хийх	м ²	201.21
32	Ариун цэвэр, душны өрөөнд цементэн зуурмаг дээр шалины хавтангаар угсрал 30x30 см	м ²	37.04
04. Дээврийн ажил			
33	Дээврийн бетон тэгшилгээг 30мм-ийн зузаантай хийх	м ²	584.22
34	Дээвэрт 1 ёс наамал шилэн даавуун тусгаарлагч хийх	м ²	584.22
35	Дээвэрт цавуут цементэн зуурмагаар хөрсжүүлэгч хийх 3 см	м ²	584.22
36	Дараагийн 1мм зузаан тутамд үнэлгээ 30-д ижмэх	м ²	8,763.30
37	Пррапед болон сувгийн хана өрөх	м ³	4.30
38	Пррапед салхинчийн суваг шавардах	м ²	77.40
39	Салхинчийн сувгийн хана шохойн будгаар , гар аргаар будах	м ²	27.80
40	Пррапедийн дээр хэвтээ ус тусгаарлагч шингэн шилтэй цементэн зуурмагаар хийх	м ²	33.04
41	Барилгын борооны усны хоолойт иж бүрнээр нь солих ф-100мм	м	50.60
05. Дотор гэрэлтүүлэг			
42	Гэрэлтүүлгийн самбар угсрал ГС-2	ш	1.00
43	Хөдөлгөөн мэдрэгчтэй гэрэлтүүлэг угсрал	ширхэг	2.00
44	Удайсах чийдэгчийн таазанд тавих хамгаалагдсан гэрэлтүүлэгч угсрал	ш	12.00
45	Таазанд хамгаалагдсан пед гэрэлтүүлэгч угсрал	ш	34.00
46	Далд утасны иж түйлт унтраалга тавих	ширхэг	18.00
47	Далд утасны хоёр түйлт унтраалга тавих	ширхэг	3.00
48	1 фазын газардуулгын контакттай далд тоноглох 2 түйлт срдийн розетка тавих	ширхэг	14.00
49	1 фазын газардуулгын контакттай далд тоноглох хамгаалагдсан 2 түйлт розетка угсрал	ширхэг	1.00
50	1 фазын газардуулгын контакттай шаланд далд тоноглох хамгаалагдсан 2 түйлт розетка угсрал	ш	5.00
51	Розетка унтраалагчны блок, утас салбарлах хайрцаг угсрал	ш	41.00
52	Утас салбарлах хайрцаг угсрал	м	21.00
53	Зэс голтой ПВ тусгаарлагчтай 1x2.5мм ² огтолтой 1-р утас сувдэх	м	1,000.00
54	Зэс голтой ПВ тусгаарлагчтай 1x4 мм ² огтолтой дараагийн утас угсрал	м	300.00
55	10мм ² хүргэлтийн огтолтой иж ба олон судастай дараагийн утас бүрийн сувдэх	м	20.00
56	Үүн пластмасан хар хоолойт угсрал Ф 20мм	м	450.00
57	50*50*5мм хэмжээгийн булан темэр газардуулагчын гар ажилгаагаар зох	ш	18.00
58	40x4 мм ² хүргэлтийн огтолтой газардуулгын шинийг шуудуунд угсрал	м	200.00

"Тохиижилт Сайншанд" хот тохиижилтийн газрын конторын барилгын засварын ажил

Д/д	Ажилбарын нэр	Хэмжих илгэж	Тоо
59	8мм хуртэл голчтой бөөрөхийн цайрласан темреер азигын төр угсрал	м	100.00
66	Аянига хамгаалалт буулгах утас Ф 130мк	м	6.00
06. Дотор бохир усны ажил			
61	Шаазан утаагуур тавих	ш	2.00
62	Шаазан зайлхэй торхтой суултуур байрлуулах	1ком	2.00
63	Угаагуурын холигч байрлуулах	ш	2.00
64	Дүүшинд трап угсрал / голч-100мм/	1ш	2.00
65	Усны мэдрэгчтэй ханын ганцаарцисан хотевч тавих	1ш	1.00
99.Хог хаягдлын дун			
66	Хог хаягдал	ти	0.00

"Тохиижилт Сайншанд" хот тохиижилтын газрын конторын барилгын засварын ажил

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

“Тохиижилт Сайншанд” хот тохиижилтын газрын конторын барилгын засварын ажил

A. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчиний тоо-/ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлаг, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

B. Соёлын төвийн барилгын засварын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНБД/, стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх

B. Үнийн санаад зураг төсвийн үйлг 2 100 000 /Хөөр сая нэг зуун/ төгрөгөөр тооцох, захиалагчийн хяналтын зардлыг Барилга угсралтын ажлын төсөөтөртгийн дүнгийн 2%-иар, зохиочийн хяналтын зардлыг захиалагчийн хяналтын зардлын 50%-иар тооцож тусгажс ирүүлнэ.

G. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах тослийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулж

D. Барилгын их засварын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ.

1. Буулгах ажил

- Конторын барилгын дотор хана, таазны суларч хөндийрсөн шаврыг ховхолж унаган, хуучин будагтай гадаргууг 100% хусаж цэвэрлэнэ. Паркетан шал болон ариун цэврийн өрөөний хана шалны плитаг задалж буулгана. Барилгын дээвэр дэх шавар болон хуучин хар цаасыг хуулж буулгана. Буулгалтын ажлын явцад барилгаас гарсан хог хаягдлыг зориулалтын хогийн цэгт асгана.

Буулгалтын ажил гүйцэтгэх үед хөдөлмер хамгаалал, аюулгүй ажиллагааг чанд мөрдөж ажиллана.

2. Дотор заслалын ажил

- Дотор хуурай ба нойтон шавардлага, будаг, цааслалт, шиллэгээ, өнгөлгөөний ажилд Заслалын ажил /БНБД 31-10-05/-г мөрдлөг болгоно. Заслалын ажилд хэрэглэх материалууд нь MNS5252:2003, MNS4584:98, MNS4581:2003 техникийн шаардлагыг хангасан байна.

- Гадна агаарын температур +8 хэмээс багагүй, өрөөний температур +10 хэмээс багагүй үед заслалын ажлыг гүйцэтгэнэ.

- Цонхны амалгааны засварын ажил БНБД 3.04.02-88-г мөрднө.

- Хаалга, цонхны ажилд БНБД 81-55-05, MNS 5803:2008 дагуу гүйцэтгэх ба модон здэлхүүний материалд улсын стандарт MNS3944:1998-г мөрднө.

- Шалны ажилд БНБД 3.04.04-90, БНБД- 81-11-06 мөрдлөг болгоно.

-Өрөө тасалгааны хуучин хаалга, паркетан шал зэргийг бүхэлд нь задалж буулган, хуучин хана, таазны гадаргуут сайтар хусаж цэвэрлэн технологийн дагуу бэлтгэсний дараа сайн чанарын тэгшилгээ хийж огно.

-Шинээр хийх паркетан шал, өнгөт хавтан, ханын будаг зэргийн өнгөний зохицол хоорондоо тохиромжтой байх бөгөөд өнгөт үзэмж, чанар сайтгайт сонгон хэрэглэнэ.

-Душны өрөөний ханын 1.6м-ийн түвшинд плита наана, ариун цэврийн өрөөнд зориулалтын өнтөт хавтангаар тусгаарлах хана, таазанд лампирэн хавтан өнгөлгөөг тус тус хийнэ. Ариун цэвэр, душны хувцас солих өрөөний ханыг 3D хавтангаар бүрнэ.

- Өрөө тасалгааны өнгөний сонголтыг хийхдээ захиалагч, ашиглагч байгууллагатай харилцан зөвшүүлсөх шаардлагатай.

3. Шалны ажил

- Шалны ажилд БНБД 3.04.04-90, БНБД- 81-11-06 мөрдлөг болгоно.

- Хуучин шалыг хуулж, OSB хавтангаар өрөө тасалгааны муудсан шаланд тэгшилгээ хийнэ. Мөн БМ100 маркийн бетон дэвсгэр үе дээр 20 мм-ийн зузаан цементэн тэгшилгээ хийсний дараа хэмжилтийн зурагт заасан өрөөний шалны бүтцийн тодорхойллын дагуу паркетан шал, чулуун хавтан шал, хулдаасан шалыг технологийн дагуу хийнэ. Шал тус бүрт зориулалтын хөвеөг хийж огно.

4. Дээврийн ажил

- Дээврийн ажлыг гүйцэтгэхдээ БНБД 31-02-03, БНБД 31-07-05, БНБД 31-08-05 бусад норм, стандартыг мөрдлөг болгоно.

-Дээврийн бетон тэгшилгээг 30см-ийн зузаантай хийсний дараа дээвэрт 1 үе наамал шилэн даавуун тусгаарлагч хийнэ. Түүний дараа дээвэрт 3см-ийн зузаан павуут зуурмагаар хөржүүлэгч хийнэ. Мөн прапед болон сувгийн хана өрж шавардсаны дараа шохойн будгаар будна. Пррапедны ханын дээр шингэн шилтгэй цементэн зуурмагаар хэвтээ ус тусгаарлагч хийнэ.

5. Дотор гэрэлтүүлгийн ажил:

-Цахилгааны монтажны угсралтын ажлыг гүйцэтгэх үед БД43-101-03, БД 43-102-07, БНБД 81-20-04, БНБД – 81-30-04 –г мөрдлөг болгоно.

- Цахилгааны монтажны утас, унтраалга, разетка нь ус чийгнээс хамгаалагдсан ОХУ-д үйдвэрлэсэн байна. Хятад улсад үйлдвэрлэсэн цахилгааны монтажийн утас хэрэглэхийг хориглоно. Ариун цэврийн өрөөний цахилгаан тоног төхөөрөмжийг усны хамгаалалттай байхаар сонгон хэрэглэнэ.

-Аянга хамгаалалт болон газардуулгыг зураг төслийн дагуу хийж гүйцэтгэх.

-Цахилгааны ажлыг зураг төсөл, холбогдох барилгын норм дүрэм стандартын шаардлага хангасан чанартай материал сонгон авч хийж гүйцэтгэнэ.

6. Дотор бохир усны ажил:

- Дотор бохир усны системийн угсралтын ажлыг гүйцэтгэхдээ БНБД 81-16-06, БНБД 81-17-06-г мөрдлөг болгоно.

- Хуучин тоноглолуудыг авч шинээр угаагуур, суултуур, холигч, усны мэдрэгчтэй ханын ганцаарчилсан хотөвч зэргийг төсөвт тусгагдсан тоо ширхэгийн дагуу угсарч байрлуулна.

Төндөрт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Барилгын засварын ажлыг батлагдсан зураг тесөл, ажлын тоо хэмжээний дагуу чанарын ондor түвшинд, гэрээний хутацаанд багтаан гүйцэтгэнэ.

2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
3. Барилгын засварын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.
4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.
5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.
6. Барилгын засварын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж егнэ.
7. Барилгын зураг төсөлд зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт оруулах болвол захиалагч болон зураг төслийн байгууллагатай зөвшшилцене. Зөвшөөрөлгүйгээр газар дээр өөрчлөхийг хориглоно.
8. Барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу ашиглалтанд хүлээлгэн өгснөөс хойш зугшруулэх, тохиуулах хугацаа нэг жил байна. Энэ хуулийн 14.6 заасны дагуу 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хий, бүтээц, цэвэр бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа доошгүй жил байна.
9. Гүйцэтгэсэн ажлыг ил, далд ажлын акт, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.
10. Хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу егнэ. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.
11. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтглийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохионч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлийн.
12. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлэсгүй нохцэлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.
13. Үнийн саналд Барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 181 тоот тушаалын дагуу нэмэгдэл зардал, төлөвлөгөөт ашиг, техник хяналт, нормчлолын сан, НӨАТ, магадлашгүй ажлын зардал зэргийг тооцож Барилгын төсөв зохиох дүрэм БНБД "ТУ" 81-95-12-г мөрдлөг болгоно.
14. Үнийн тарифийг тооцон ирүүлэхдээ ажилбар тус бүрээр тооцож ирүүлийн.

Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

- (а) гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;
- (б) гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарын заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарыт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өртгийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарыт заавал оруулна.

Ажил-өдрийн хуваарь

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваары нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

- (а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.
- (б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг баатасан байна.

Магадлашгүй зардал

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарыт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарыт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон

тендерийн баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулаагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.

Долоо. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|--|
| <p>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</p> <p>2. Төслийн менежерийн шийдвэр</p> <p>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</p> <p>4. Аюулгүй байдал</p> <p>5. Зааварчилгаа</p> <p>6. Маргааныг шийдвэрлэх</p> <p>7. Ажлын хөтөлбөр</p> <p>8. Зөрчил, гологдол илрүүлэх</p> <p>9. Зөрчил, гологдол арилгах</p> <p>10. Зөрчил,</p> | <p>1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p>2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.</p> <p>3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.</p> <p>4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.</p> <p>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгтын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.</p> <p>5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй</p> <p>6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гарана.</p> <p>B. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</p> <p>7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхдэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.</p> <p>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.</p> <p>8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдолын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.</p> <p>9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа¹ дуусхаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдолыг арилгаж дуусах хүртэл сунгана.</p> <p>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдолыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.</p> <p>10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдолыг төслийн менежерийн</p> |
|--|--|

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

**гологдол
арилгахгүй
байх**

мэдэгдэл заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнэ. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
- Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**
- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

авлага

заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буудсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: АЗДТГ-ЫН 0НХС/ХА-24/2020
ГЕН 2.1	АЗДТГ-ЫН гадна фасад засварын ажил
ГЕН 3.1	Төслийн менежер нь ГХБХБГ-ЫН Барилгын хэлтсийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн Б.Билэгдэлгэр
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр 2020.02.20 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр 2020.05.30
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [ажлын 5] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 36 сар байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн [1 хувь] байна. ⁴ Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн [10 хувь] байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг [2020.05.30] -ний дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг [2020.05.30-ны] дотор гаргаж өгнө. Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ [500 000 төгрөг] байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын [1 хувь] -иар тооцно.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна.
Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

⁴ Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;

- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцуулэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]